

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын
2025 оны 02 дугаар сарын 30-ны өдрийн 02/162
дугаар албан бичгийн нэгдүгээр хавсралт



НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗАР

Иргэдээс ирүүлсэн хүсэлтийн шийдвэрлэлтийн тайлан

/2025 оны хагас жилийн байдлаар/

1. 2025 оны 01 дүгээр сарын 02-ноос 06 дугаар сарын 25-ны байдлаар иргэдээс 10 хүсэлт, 10 гомдол, 1 санал ирүүлсэн нь өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 13 өргөдөл, гомдлоор их байна.

(Хүснэгт)

Үзүүлэлт	2024.01.01 – 06.25		2025.01.01 – 06.25	
	Ирсэн тоо	Хувь	Ирсэн тоо	Хувь
Хүсэлт	4	100%	10	100%
Гомдол	2	100%	10	100%
Санал	2	100%	1	100%

2025.01.01-нээс 2025.03.25-ны хооронд иргэдээс ирүүлсэн 1 санал, 10 хүсэлт, 10 гомдлыг хүлээн авч, удирдлага, холбогдох албан хаагчдад шилжүүлж, шийдвэрлэлтийн мэдээг 14 хоног бүр байгууллагын удирдлагад танилцуулж, мэдээлэл хийснээр өргөдөл, гомдлыг ажлын 1 хоногт багтаан шийдвэрлэсэн. Үүнд:

1.0250116105 дугаартай хүсэлт: Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын Спорт, нийтийн биеийн тамирын хэлтсийн Спортын наадам, спорт холбоодын асуудал хариуцсан мэргэжилтэн Ганболдын Ууганжаргал өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдөх хүсэлт гаргасанг хүлээн авч байгууллагын даргын 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн Б/02 дугаар тушаалаар Г.Ууганжаргалыг төрийн албанаас чөлөөлж иргэний талд шийдвэрлэсэн.

2.025023061 дугаартай хүсэлт: Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн Хүний нөөц хариуцсан мэргэжилтэн Б.Оюунтуяа нь 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдрөөс эхлэн жирэмсний амралт олгож өгөхийг хүссэн хүсэлтийг байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 7.14 дэх заалтыг үндэслэн байгууллагын даргын Б/07 дугаар тушаалаар жирэмсний болон амаржсаны амралтыг олгон иргэний талд шийдвэрлэсэн.

3.0250203115 дугаартай хүсэлт: Сүхцоодол овогтой Хархад нь Нийслэлийн Биеийн тамир, спортын газарт ажилд орох хүсэлт гаргасанг хүлээн авч байгууллагын даргын 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн Б/05 дугаар тушаалаар Спорт, нийтийн биеийн тамирын хэлтсийн Спортын тэмцээн наадам, спортын холбоод хариуцсан мэргэжилтний албан тушаалд томилж иргэний талд шийдвэрлэсэн.

4.О250203133 дугаартай хүсэлт: Содномдоржийн Ганчимэг нь агентлаг хариуцсан нягтлан бодогчоор ажиллаж байгаад Нийслэлийн Биеийн тамир, спортын газарт хариуцсан нягтлан бодогчоор ажилд орох хүсэлт гаргасанг хүлээн авч байгууллагын даргын 2025 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн Б/06 дугаар тушаалаар томилон иргэний талд шийдвэрлэсэн.

5.G250205076 дугаартай гомдол: О.Оюунцэцэг /99062568/ тэшүүрийн холбооноос 7-8 настай хүүхдүүдийг гадаа уралдуулна гэж байна. Хүйтний эрч эрс чангарч, цаг агаарын урьдчилсан мэдээгээр сэрэмжлүүлж байхад огт хүлээж авахгүй байгаад гомдол гаргасан. Биеийн тамир, спортын газраас зохион байгуулж буюу Улаанбаатар хотын аварга шалгаруулах шорт трекийн тэмцээн 7-8 насны ангилал ороогүй болохыг мөн олон улсын стандартын дагуу хүүхдүүд гадаа талбайд -21 температурт гулгах боломжтой байдаг гэдгийг холбогдож мэдээлж боломжгүй тухай тухай өгсөн.

6.G250219092 дугаартай гомдол: Л.Алтангэрэл: Яармагийн Дээдсийн өргөө 9090-2 байрны 1 давхарт нь спиннинг ажиллуулж амгалан тайван байдал алдагдуулж байгааг шалгаж өгөх гомдол гаргасан. Гомдлыг хүлээн авч хариу мэдэгдэж иргэний талд шийдвэрлэсэн.

7.G250318118 дугаартай гомдол: Д.Болормаа нь Монголын волейболын холбооноос Волейболын клубийн аварга шалгаруулах тэмцээнийг телевизээр үзэж тоглолтын онооны тал нь гараад харагдахгүй байгаа тухай 11344340 дугаарт хандахад хүлээн авахгүй байна гэсэн гомдлыг Монголын волейболын холбоотой холбогдож, хариуг мэдээлж иргэний талд шийдвэрлэсэн.

8.C250402001 дугаартай хүсэлт: Д.Оюунтунгалаг /99102172/ нь ХУД-ийн Спорт хорооноос зохион байгуулсан теннисний тэмцээнд Харумафужи сургуулийг 1-р байранд оруулсанд нь гомдол гаргасан. Гомдлын дагуу тус сургууль багийн дүнгээр 1-р байр эзэлсэн тухай шийдвэрийг мэдэгдэж, боломжгүй тухай хариу өгсөн.

9.G250402139 дугаартай гомдол: Д.Оюунтунгалаг /99102172 ХУД-ийн спорт хорооны зохион байгуулсан ширээний теннисний тэмцээний үеэр багийн дүнгээр 1, 2 дугаар байр эзэлсэн байранд санал дийлэхгүй байгаа тухай гомдол гаргасан. Гомдлын дагуу олонхын саналаар шийдвэрлэсэн тухай мэдэгдэж иргэний талд шийдвэрлэсэн.

10.G250428174 дугаартай гомдол Б.Ариунаа /88087102/ Хүүхдийн уран гимнастикийн тэмцээний шүүлт шударга бус тухай гомдол гаргасан. Боломжгүй тухай хариу өгсөн.

11.G250502185 дугаартай хүсэлт: Б.Энхсүлд /99012046/ Нийслэлийн биеийн тамир, спортын газар болон Монголын Гимнастикийн холбооны Ерөнхий нарийн бичгийн дарга, аэробик гимнастикийн олон улсын хэмжээний мастер, олон улсын хэмжээний шүүгч Г.Ерөөлбатад гомдол гаргасан. Гомдлыг тэмцээний удирдамжийн шүүлтийг явуулж шударга бус болон удирдамж зөрчсөн шийдвэрийг гаргаагүй болно гэсэн хариу өгч боломжгүй тухай хариу өгсөн.

12.G250505099 дугаартай хүсэлт: Г.Анужин /99293494/ Улаанбаатар хотын цэцэрлэгийн хүүхдийн уран хөдөлгөөнт гимнастикийн тэмцээн манай 114-р цэцэрлэгийн 30 тамирчин хүүхдүүд оролцон шүүгчдийн өгсөн нийт үнэлгээгээр 16.750 оноо аван 6-р байрт орсонд санал нийлэхгүй байгаад гомдол гаргасан. Боломжгүй тухай хариу өгсөн.

13.G250520147 дугаартай гомдол: Ц.Амударъяа /99181565/ нь Улаанбаатар марафон олон улсын гүйлтийн бүртгэлийг хугацаанаас өмнө хаасанд гомдол гаргасан. Гомдлыг 99181565 утсаар холбогдон гомдолтой танилцаж 10 км зайн төрөлд гүйх хүсэлтийг хүлээн авч дагалдах хэрэгсэл, энгэрийн дугаарыг олгож иргэний талд шийдвэрлэсэн.

14.G250521101 дугаартай гомдол: Э.Нандинцэцэг /80195511/ Улаанбаатар марафон олон улсын гүйлтэд бүртгүүлэхэд энгэрийн дугаар өөр хүнд олгосон байсан тухай гомдлын дагуу тодруулахад энгэрийн дугаар өөр хүнээр авхуулахад сольж өгсний улмаас асуудал үүссэн байна. Энгэрийн дугаарын зөрүүг бүртгэлийн цэг дээр очиж залруулсан гомдолгүй тухайгаа мэдэгдсэн. Боломжгүй тухай хариу өгсөн.

15.G250526083 дугаартай хүсэлт: Г.Эрдэнэзаяа /86080046/ Улаанбаатар марафон олон улсын гүйлт зохион байгуулалтыг сайжруулах талаар хүсэлтийг хүлээн авч иргэний талд шийдвэрлэсэн.

16.G250527052 дугаартай гомдол: З.Нина /89114692/ нь Улаанбаатар марафон олон улсын гүйлтэд оролцоход насны ангилал зааж байгаад гомдол гаргасан. Дараа жилийн удирдамжид өөрчлөлт оруулах тухай мэдэгдэж иргэний талд шийдвэрлэсэн.

17.G250527072 дугаартай гомдол: Ж.Элдэв-Очир /94441620/ Улаанбаатар марафон олон улсын гүйлтэд 21 км-ийн зайн төрөлд бүртгүүлэх хугацаа дууссаны дараа бүртгэл хийлгэж баталгаажуулах гомдол гаргасан. Гомдол гаргасан иргэнтэй утсаар холбогдож холбогдох журмыг тайлбарлаж ойлголцолд хүрч боломжгүй тухай хариу өгсөн.

18.G250529123 дугаартай санал: Ж.Нямдаваа /88282908/ нь түгжрэлтэй үед уралдаан тэмцээнүүдийг хөдөлгөөн сийрэг газар зохион байгуулах талаар санал гаргасан. Саналыг хүлээж авч иргэний талд шийдвэрлэсэн.

19.G250605226 дугаартай хүсэлт: Б.Ган-Эрдэнэ /89999872/ Улаанбаатар марафон олон улсын гүйлтэд 00227 дугаартай оролцож finisher medal-иа нөхөж авах хүсэлт гаргасанд дурсгалын медалийг Нийслэлийн Биеийн тамир, спортын газарт очиж авах талаар мэдээллийг өгч иргэний талд шийдвэрлэсэн.

20.G250616129 дугаартай хүсэлт: Б.Ананд /99070805/ Улаанбаатар марафон олон улсын гүйлтэд зохих төлбөрөө төлж хэрэгслүүддээ авч 21 км гүйсэн боловч өнөөдрийг болтол цагийн мэдээлэл, гүйлтийн зургууд ulaanbaatar.marathon.mn ороогүй байгаад гомдол гаргасны дагуу "Хайпэй" ХХК-ийн программ хөгжүүлэлт хариуцсан ажилтан Н.Пүрэвцэцэгтэй холбогдож тухайн гүйгчийн 2022, 2023 оны "Улаанбаатар марафон" олон улсын гүйлтэд гүйж барианд орсон цаг нь танигдаагүй, уншигдсан зарим цэгийн цаг, зургийг anand0815@yahoo.c om мэйл хаяг руу нь хүргүүлж иргэний талд шийдвэрлэсэн.

21.G250618155 дугаартай гомдол: Б.Ананд /99070805/ Улаанбаатар марафон олон улсын гүйлтэд 21км-т бүртгүүлэн гүйж зураг олдоогүй, чип таниагүй улмаас бүртгэлийн хураамжийг буцаан олгож өгөхийг хүссэн. Гомдолтой танилцаж, "Улаанбаатар марафон-2025" онд 30244 дугаартай 21км зайд гүйж барианд орсон боловч 2022, 2023 онуудынх шиг гүйсэн амжилт цагийн бүртгэл нь гараагүй, чип нь ажиллаагүй, 2025 онд оролцсон зураг нь олгогдоогүй зэрэг асуудлыг "Хайпэй" ХХК-тай ярилцаж тухайн оролцогчийн бүртгэлийн хураамж 70,000 (далан мянган) төгрөгийг буцаан олгохоор иргэний талд шийдвэрлэсэн.

2025.01.02-ноос 2025.06.25-ны хооронд иргэдээс ирүүлсэн 10 хүсэлт, 10 гомдол, 1 саналыг шийдвэрлэхдээ явцын тэмдэглэлийг тус бүрд 1 удаа хөтлөн явуулсан.

2. Өргөдөл гомдлын индексийн үнэлгээ 2024 оны хагас жилийн байдлаар 0,838 хувь байсан бол 2025.01.02-ноос 2025.06.25-ны хооронд 0,874 хувийн индекстэй байна.

3. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 2024 оны эхний хагас жилийн байдлаар 2 хоног 7 цаг 45 минут байсан бол 2025 онд 1 хоног, 17 цаг 53 минут болж 1 хоногоор буурсан үзүүлэлттэй байна.

ТАНИЛЦСАН:

НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ С.САРАНЦЭЦЭГ

ХЯНАСАН:

ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ,
САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА



М.ЦОГЗОЛМАА

ТАЙЛАН МЭДЭЭ ГАРГАСАН:
ХҮНИЙ НӨӨЦ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН

A stylized black ink signature, likely belonging to B. Oyuntuuya, is written below the official stamp.

Б.ОЮУНТУЯА

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын
 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн
 08/168 дугаар албан бичгийн
 хоёрдугаар хавсралт

НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
 ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙГ САЙЖРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХ
 ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2025 оны 06 дугаар сарын 27 Улаанбаатар хот

№	Хэрэгжүүлэх ажлын нэр	2025 оны хагас жилийн байдлаар		
		Одоогийн байдал	Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Хүрэх үр дүн
1.	Өргөдөл гомдлын индексийн үзүүлэлтийг дээшлүүлэхэд тухай бүр анхаарч ажиллах	2025.01.02-ноос 2025.06.25-ны хооронд иргэдээс ирүүлсэн 1 санал, 10 хүсэлт, 10 гомдлын индекс 0,874 болсон.	Байгууллагад ирүүлсэн өргөдөл гомдлын индексийг дээшлүүлэх, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн явцын мэдээллийг байгууллагын удирдлага, албан хаагчдад 14 хоногт 1 удаа танилцуулах;	Байгууллагын удирдлага, ажилтан, албан хаагчдад 14 хоног тутам байгууллагын эрх бүхий албан тушаалтанд хандсан хүсэлт, өргөдөл гомдол байхгүй талаар мэдээлсэн.
2.	Иргэдээс гаргаж буй өргөдөл, гомдлын шалтгаан нөхцөлийг байгууллагын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн нэгж, албан хаагчийн түвшинд нарийвчлан судалж, өргөдөл гомдлыг хууль зүйн үндэслэлтэй, нэг мөр эцэслэн шийдвэрлэх, хуулийн хугацаанд иргэнд хариу өгөх жишиг тогтоож ажиллах	Тайлант хугацаанд албан тушаалтанд хандаж Нийслэлийн Биеийн тамир, спортын газарт иргэдээс гаргаж буй өргөдөл, гомдлын шалтгаан нөхцөлийг байгууллагын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн нэгж, албан хаагчийн түвшинд нарийвчлан судалж, өргөдөл гомдлыг хууль зүйн үндэслэлтэй нийт ирсэн 21 өргөдлийг шийдвэрлэхэд	Байгууллагад ирүүлсэн өргөдөл гомдлыг хугацаанд нь шийдвэрлүүлэхийн тулд тухайн өргөдөл гомдлын шалтгааныг олж, холбогдох албан тушаалтан, мэргэжилтэнд шилжүүлэн, 14 хоног тутам удирдлагад мэдээлж, өргөдөл гомдлыг шийдвэрлэхэд хууль зүйн үндэслэлийг сайтар гаргаж, өргөдлийн хариуг тухайн иргэнд хугацаанд нь өгч, шийдвэрлэлтийг программд хоцроолгүй оруулах, хуулийн дагуу шийдвэрлэх;	Ирүүлсэн өргөдөл гомдлын шалтгаан нөхцөлийг тодорхойлж, холбогдох ажилтанд шилжүүлж, 14 хоног тутам удирдлагад танилцуулж, шийдвэрлэлтэд хяналт тавьж, шийдвэрлүүлснээр тухайн өргөдөл гомдлыг хууль зүйн үндэслэлтэй, эцэслэн шийдвэрлэж, хуулийн хугацаанд иргэнд хариу өгөх жишиг тогтоно.

		боломжгүй тухай хариу өгсөн 7, иргэний талд шийдвэрлэсэн 14 өргөдөл байна. 2025.01.02-ноос 2025.06.25-ны хооронд иргэдээс ирүүлсэн 1 санал, 10 хүсэлт, 10 гомдлыг хүлээж авч, удирдлага, холбогдох ажилтнуудад шилжүүлж, шийдвэрлэлтийн мэдээг 14 хоног бүр байгууллагын удирдлагад танилцуулж, мэдээлэл хийснээр өргөдөл, гомдлыг ажлын 1 хоногт шийдвэрлэсэн.		
3.	Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн хугацаа, дундаж зөрчлийн үзүүлэлтийг бууруулах	Байгууллагад иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг 2025 оны эхний хагас жилийн тайланг цахим хуудсандаа байршуулна.	Өргөдөл, гомдлын программыг өдөрт 2 удаа тогтмол шалгаж, ирүүлсэн өргөдлийг өдөрт нь шилжүүлж, шийдвэрлэлтийн мэдээг 14 хоног тутам байгууллагын удирдлага, мэргэжилтнүүдэд танилцуулж, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацааг 5 хоног болгох;	Өргөдөл, гомдлын программыг өдөрт 2 удаа тогтмол шалгаж, ирүүлсэн өргөдлийг өдөрт нь удирдлага, холбогдох ажилтнуудад шилжүүлж, шийдвэрлэлтийн мэдээг 14 хоног бүр байгууллагын удирдлагад танилцуулж, мэдээлэл хийснээр өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацааг нийслэлийн дундаж хугацаанд 5 хоног болгоно.
4.	Иргэдээс гаргасан саналын шинжтэй өргөдлийг байгууллагын үйл ажиллагаанд тусгаж, түүний мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тайлан мэдээнд тусгайлан оруулж, байгууллагын цахим хуудаст ил тод, нээлттэй байршуулж хэвших	Байгууллагад иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн 2025 оны эхний хагас жилийн тайланг цахим хуудсандаа байршуулна.	Байгууллагад иргэдээс саналын шинжтэй өргөдөл ирүүлсэн тохиолдолд үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөндөө тусгаж, хэрэгжүүлсэн биеийн тамир, спортын аливаа арга хэмжээг тайлан мэдээндээ тусгайлан оруулж, байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар болон пэйж хуудсандаа ил тод, нээлттэй байршуулж ажиглах;	Байгууллагад иргэдээс ирүүлсэн саналын шинжтэй өргөдөл шийдвэрлэгдэж, олон нийтэд ил тод болгоно.
5.	Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн явцын тэмдэглэл хөтлөх	2025.01.02-ноос 2025.06.25-ны хооронд иргэдээс ирүүлсэн 10 хүсэлт, 1 санал, 10 гомдлыг шийдвэрлэхдээ явцын тэмдэглэлийг тус	Байгууллагын удирдлага, ажилтнуудад өргөдөл, гомдлыг шийдвэрлэх явцдаа явцын тэмдэглэлийг хөтөлж байхыг зөвлөх, хяналт тавих, 14 хоног тутмын мэдээ гаргах, алдаа дутагдал, зөрчил гаргахгүй ажиглах;	Өргөдөл, гомдлыг шийдвэрлэх явцад явцын мэдээлэл тухайн иргэнд нээлттэй болж, явцын тэмдэглэл хөтөлж, шийдвэрлэлтийн индексийн үзүүлэлт дээшилнэ.

	бүрд 1 удаа хөтлөн явуулсан.		
6.	Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн улирлын тайлан мэдээний боловсруулалтад анхаарч ажиллах	2025.01.02-ноос 2025.06.25-ны хооронд иргэдээс ирүүлсэн 10 хүсэлт, 1 санал, 10 гомдлын шийдвэрлэлтийн мэдээг шаардлагын дагуу гаргаж хүргүүлсэн.	Байгууллагын өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн улирлын тайлан мэдээг гаргахдаа өргөдөл гомдлын шалтгаан, түүний мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, байгууллагын цахим хуудас болон бусад хэлбэрээр олон нийтэд мэдээлсэн зэргийг тусгаж ажиллах.
			Байгууллагын өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн улирлын тайлан мэдээнд иргэдээс ирүүлсэн саналын дагуу хийж хэрэгжүүлсэн, зохион байгуулсан арга хэмжээний тайлан, тоон үзүүлэлтийг бүрэн оруулсан байна.

ТАНИЛЦСАН:
НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА
ТАЙЛАН МЭДЭЭ ГАРГАСАН:
ХҮНИЙ НӨӨЦ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

С.САРАНЦЭЦЭГ
М.ЦОГЗОЛМАА
Б.ОЮУНТУЯА

Нийслэлийн Биеийн тамир, спортын газар
Иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээ



Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын
2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 02/162
дугаар албан бичгийн гуравдугаар хавсралт

(2025 оны 06 дугаар сарын 25-ны байдлаар)

2024/01/02 – 2024/06/25

№	Өргөдөл гомдлын агуулга	Нийт тоо	Хэлбэр					Агуулга				Шийдвэрлэж хариу өгсөн			Шийдвэрлэж байгаа	
			Амаар	Бичгээр	Утсаар	11-11 төвөөс	1800-1200 утаснаас	Дээд байгууллагаас ирсэн	Талархал	Санал	Хүсэлт	Гомдол	Хуулийн хугацаанд хариу өгсөн	Хугацаа хэтэрч хариу өгсөн	Бусад байгууллагад шилжүүлж хариу өгсөн	Хугацаа болоогүй
1	Цахим програмд бүртгэгдсэн	21	0	4	0	16	1	0	1	10	10	21	0	0	0	0
2	Цахим програмд бүртгэгдээгүй	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
ДҮН:		21	0	4	0	16	1	0	1	10	10	21	0	0	0	0

ТАНИЛЦСАН:
НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

ТАЙЛАН МЭДЭЭ ГАРГАСАН:
ХҮНИЙ НӨӨЦ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН



Б.ОЮУНТУЯА

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын
2025 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн...
дугаар албан бичгийн дөрөвдүгээр хавсралт

**НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗАРТ
ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТЭД
ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ**

/2025 оны хоёрдугаар улирлын байдлаар/

2025 оны 06 дугаар сарын 26-ны өдөр

Улаанбаатар хот

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын өргөдөл, гомдлын шийдвэрлэлт холбогдох хууль, дүрэм, журмын дагуу явагдаж байгаа эсэхийг шалгаж, ажлын үр дүнг тооцох, цаашид анхаарах асуудлаа тодорхойлж, үйл ажиллагааг сайжруулах талаар санал, зөвлөмж өгч, дэмжлэг үзүүлэх зорилгоор дүн шинжилгээ хийв.

НБТСГ-ын өргөдөл, гомдлыг хүлээн авах хэлбэр:

Иргэн, хуулийн этгээдээс өргөдөл гомдлыг Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын бүртгэл, Засгийн газрын "11-11 төв"-ийн оператор, 1800-1200 дугаарын оператор зэрэг хэлбэрээр хүлээн авч байна.

Хүлээн авсан өргөдөл гомдол:

2025 оны 01 дүгээр сарын 02-ноос 06 дугаар сарын 25-ны байдлаар иргэдээс хүсэлт-10, гомдол-10, санал-1, нийт 21 өргөдөл ирүүлсэн нь өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 13 өргөдөл, гомдлоор ихэссэн байна.

Хүснэгтээр харуулбал:

Үзүүлэлт	2024.01.01 – 06.25		2025.01.01 – 06.25	
	Ирсэн тоо	Хувь	Ирсэн тоо	Хувь
Хүсэлт	4	100%	10	100%
Гомдол	2	100%	10	100%
Санал	2	100%	1	100%

Өргөдөл, гомдлын хандалтын тайлан

Д/д	Ангилал	Өргөдөл, гомдлын тоо	Өргөдөл гомдлын хувь
1	Биеийн тамир, спортын арга хэмжээний тухай	9	42.86%
2	Нийслэлийн Засаг даргын Хэрэгжүүлэгч агентлагуудын үйл ажиллагааны тухай	4	19.05%
3	Ажилд орох тухай	2	9.52%
4	Хоолны газар, баар, рестораны үйлчилгээний тухай	1	4.76%
5	Урлаг соёлын арга хэмжээний тухай	1	4.76%
6	Жирэмсний амралтын тухай	1	4.76%

7	Ажлаас чөлөөлөгдөх тухай	1	4.76%
8	Биеийн тамир, спортын салбарын үйл ажиллагааны тухай	1	4.76%
9	Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний тухай	1	4.76%
Нийт өргөдөл, гомдлын дүн		21	100.00%

Тайлант хугацаанд иргэдээс байгууллага, албан тушаалтанд хандаж 10 хүсэлт, 10 гомдол, 1 санал ирүүлснийг өдөрт нь хүлээн авч, шийдвэрлэлтийн дундаж хугацааг 1 хоног 17 цаг 53 минут болсон. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн индекс 0,874 болж өссөн.

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн 2025 оны хоёрдугаар улирлын биелэлтийг Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвд албан тоотоор тайлагнаж, гаргасан тайлан мэдээг байгууллагын www.sport.ub.gov.mn цахим хуудсанд байршуулсан.

ТАНИЛЦСАН:

НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ С.САРАНЦЭЦЭГ

ХЯНАСАН:

ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ,
САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

ТАЙЛАН МЭДЭЭ ГАРГАСАН:
ХҮНИЙ НӨӨЦ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН



М.ЦОГЗОЛМАА

Б.ОЮУНТУЯА